



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 130

Номгон

Зарим газар нутгийг аймгийн
тусгай хамгаалалтад авах тухай

Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүн Лхагваагийн Элдэв-Очир, Галуут сумын Үнэгтийн 3 дугаар багийн санал, нутгийн ард иргэдийн хүсэлт, өргөдөл, Зарим газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангилалаар аймгийн тусгай хамгаалалтад авах тухай аймгийн Засаг дарга Г.Батжаргалын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд тус газар нутаг нь Өлзийт голын ай сав бөгөөд Бөөнцагаан нуур, Байдраг голын гол цутгал, Дархан цаазтай амьтан аргаль, янгир, цоохор ирвэс тогтвортой нутагладаг, байгалийн өвөрмөц тогтоц бүхий унаган төрхөөрөө байгаа хамгаалах шаардлагатай нутаг юм.

Мөн дээрх газар тухайн нутгийн малчдын өвөлжөө, хаваржааны гол цөм, гол мөрний усан сан бүхий газар, эмийн болон ховор ургамлын өлгий нутаг мөн болохыг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. "к", 19 дүгээр зүйлийн 19.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Байгалийн ховор болон нэн ховор амьтан ургамлыг хамгаалах, нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Бөмбөгөр, Галуут сумын зааг нутаг дэвсгэрийг хамарсан 28860 га газрыг Байгалийн нөөц газрын зориулалтаар 15 жилийн хугацаагаар аймгийн тусгай хамгаалалтад авсугай.

2. Аймгийн тусгай хамгаалалтад авсан Байгалийн нөөц газрын хилийн зааг, эргэлтийн цэгийг нэгдүгээр, байгалийн нөөц газрын хамгаалалтын дэглэмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

0117300

3. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

3.1 Аймгийн тусгай хамгаалалтад авсан газрын тогтоолыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хуулийн хугацаанд хүргүүлсүгэй.

3.2 Тусгай хамгаалалтад авсан газартай давхцаж байгаа Гацуурт ХХК-ний ашигт малтмалын ашиглалтын MV-011917 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн 624607 га, "Сайенс Элементс" ХХК-ний хайгуулын XV-015445 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн 551.23 га талбайг цуцлуулах тухай хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газарт уламжилсугай.

4. Газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан хамгаалалтын дэглэмийг мөрдөж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга, компаний захирал, ард иргэдэд үүрэг болгосугай.

5. Газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан эрх ашиг нь хөндөгдөж байгаа аж ахуйн нэгжүүд нөхөн төлбөрийн тооцоог гарган 2017 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэхийг холбогдох компаний захирлуудад даалгасугай.


6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 05-ны
өдрийн 130 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Байршил: Банкхонгор аймаг
Галуут, Бөмбөгөр сумын зааг
Талбайн солилцоол:

| Цэг | Уртраг | Өргөрөг |
|-----|--------|------------------|
| 1 | 99 53 | 5 46 39 22 |
| 2 | 99 54 | 18 46 38 11 |
| 3 | 99 53 | 52 46 37 44 |
| 4 | 99 53 | 35 46 37 3 |
| 5 | 99 53 | 7 46 36 59 |
| 6 | 99 51 | 42 46 35 31 |
| 7 | 99 51 | 41 46 34 21 |
| 8 | 99 50 | 42 46 34 15 |
| 9 | 99 49 | 32 46 34 1 |
| 10 | 99 48 | 29 46 33 32 |
| 11 | 99 45 | 43.35 46 28 32.4 |
| 12 | 99 37 | 31.61 46 30 53.7 |
| 13 | 99 33 | 17.79 46 34 23.9 |
| 14 | 99 45 | 52 46 39 19 |

Талбайн хэмжээ: 28657 га

Масштаб М1:100 000

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 05-ны
өдрийн 130 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялагийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр тусгай зориулалтаар ан агнах, уламжлалт аж ахуй эрхлэх, байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах, уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх, нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах болно.

2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.